



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 0161

Баян-Овоо

**Засаг даргын нөөц сангаас зардал
гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Иргэдийн оролцоо-Багийн хөгжил” уриан дор сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, багийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулагдаж буй багуудын урлаг спортын наадмын шагналын зардал гаргасугай.

2. Зардлын 320000 (Гурван зуун хорин мянган) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД

010000158